



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН
- 2017 -



АГУУЛГА

- 02-07** **КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА**
Компанийн 2021 он хүртэлх дунд хугацааны стратегийн зорилт
Бүтэц зохион байгуулалт
Брэндүүд
- 08-13** **БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
Онцлох үйл явдлууд
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
Шинэ коллекциуд
Нийгмийн хариуцлагын тайлан
- 14-19** **САНХҮҮГИЙН ТАЙЛАН**
Санхүү, үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд
Санхүүгийн тайлан
Их хэмжээний хэлцэл
Сонирхлын зөрчилтэй хэлцэл
Зээлийн мэдээлэл
Компанийн удирдлагын зардал
- 20-21** **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА**
Хувьцааны арилжаа
Ногдол ашиг
- 22-30** **КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**
Засаглалын тогтолцоо
Хувьцаа эзэмшигчид
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Төлөөлөн удирдах зөвлөл
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
Эрх бүхий албан тушаалтнууд



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	Говь ХК
Үйл ажиллагааны чиглэл	Ямааны ноолуур, тэмээний ноосонд боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх
Компанийн албан ёсны хаяг	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК Утас: (976)-70139977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Вэб сайт: www.gobi.mn Фэйсбүүк: GobiCashmere
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга Дамбын ГЭРЭЛМАА Гүйцэтгэх захирал Цагаачийн БААТАРСАЙХАН
Үүсгэн байгуулагдсан огноо	1981 оны 9 сарын 5-ны өдөр
Ажилчдын тоо	1,606
Дүрмийн сан	780,112,500 төгрөг
Хүчин чадал	750 тонн түүхий ноолуур боловсруулах 500 тонн ээрмэл утас, 25 тонн нарийн ээрмэл утас хийх 1,000,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1,100,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 100,000 ширхэг ноолууран пальто үйлдвэрлэх
Гэрчилгээ, батламж	1994 онд ISO9001 “Чанарын удирдлагын тогтолцоо” 1997 онд “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх гэрчилгээ 1999 онд ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC17025:2007) стандартын шаардлага хангасан ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ЛАБОРАТОРИ 1999 онд ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC17025:2007) стандартын шаардлага хангасан НЭГДСЭН ЛАБОРАТОРИ 2016 онд H-1, 02, 03, 57 код бүхий өнгийн утсаар хийгдсэн бүтээгдэхүүн “Органик бүтээгдэхүүн” эко шошго хэрэглэх эрх

ЭРХЭМ ЗОРИЛГО

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнэтэй байгууллага байна.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

- Компанийнхаа төлөө зүрх сэтгэл, бүхий л авьяас чадвараа дайчлан ажиллаж буй чадварлаг мэргэжилтэн, ажилтнууд
- Бидэнтэй үргэлж хамт байдаг нийт хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд
- Дэлхийд хосгүй Монгол ноолуур
- Дэлхийн дэвшилтэт технологийн үйлдвэр

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль, дүрмийг чандлан сахиулна
- Хүний эрхийг дээдэлнэ
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна

УРИА ҮГ

Дэлхийд танигдсан Монгол брэнд



КОМПАНИЙН 2021 ОН ХҮРТЭЛХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

БРЭНДИНГ ХӨГЖҮҮЛЭЛТ

Цаашид ГОВЬ болон YAMA брэндийг зорилтот зах зээлд, загвар дизайны өргөн сонголттой, онцлог шийдэлтэйгээр дэлхийн зах зээлд амжилттай нэвтрүүлж, дэлхийн 100% ноолууран пальтоны №1 үйлдвэрлэгч, борлуулагч болох зорилттой байна.

БОРЛУУЛАЛТ

2017 оны борлуулалтыг 24% өсөлттэйгөөр төлөвлөж байгаа ба цаашид 2021 он хүртэл жил бүр дунджаар 23%-ийн өсөлттэйгөөр борлуулалтыг төлөвлөсөн.

2021 онд Компанийн нийт борлуулалтыг 300 тэрбум төгрөг болгож 2016 оны гүйцэтгэлээс 3.4 дахин өсгөх зорилттойгоор ажиллана.

Гадаад зах зээл дээрх ГОВЬ брэндийн нэрийн дэлгүүр болон франчайзингийн стратегийг газар зүйн бүс болон зах зээл бүрийн онцлогт тохируулан боловсруулж 2021 онд дэлхийн өнцөг булан бүрд ГОВЬ, YAMA брэндийг хүргэн дэлгүүрийн тоог 100-д хүргэж өөрийн нэрийн 20 дэлгүүртэй болохыг зорьж байна.

Дотоод зах зээл дээр тэргүүлэгч байр сууриа улам бэхжүүлэн, дэлхийн жишигт нийцсэн чанар үйлчилгээ бүхий бүтээгдэхүүнээр дотоодын хэрэглэгчдэд үйлчлэх болно.

ЧАНАР

Бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог сайжруулж, 2015 онд шинэчлэн батлагдсан олон улсын чанарын MNS/ISO 9001:2015 стандартыг 2017 онд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа.

Салбарын олон улсын стандарт болох BSCI (Business Social Compliance Initiative)-г Монголд анх удаа нэвтрүүлэн дэлхийн алдартай брэндүүдтэй хамтран ажиллах боломжийг нээн ажиллана.

Монгол ноолуурын чанарыг сайжруулах урт хугацааны стратегийн төлөвлөгөөг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулан ажиллах алсын хараатайгаар үйл ажиллагаандаа төлөвлөж байна.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог сайжруулж аюулгүй ажиллагаагаар улсын хэмжээний жишиг компани болж ажиллан энэ чиглэлийн үйл ажиллагааг сайжруулах тогтолцоог бүрдүүлэн ажиллах болно. Улмаар MNS/OHSAS18001 стандартыг нэвтрүүлнэ.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ


Говь брэндийн онцолсон стратегийн 5 бүтээгдэхүүн болох

1. Пальто, пиджак
2. Нимгэн сүлжмэл
3. Энгийн сүлжмэл
4. Ороолт, шааль
5. Хөнжил-ний үнийн бодлогын стратеги, загвар дизайныг газар зүйн бүс нутаг бүрээр боловсруулан, чанарын хяналтыг тогтмол барин тогтворжуулж, зах зээл бүрдээ тохирсон онцлог бүхий бүтээгдэхүүнийг Дэлхийн зах зээл дээр санал болгон ажиллана.

Бүтээгдэхүүний загвар дизайныг улам төгөлдөржүүлэн сайжруулж дэлхийн загварын чиг хандлагатай хөл нийлүүлсэн коллекцийг улирал тутамд дотоод болон гадаадын зах зээл дээр гарган Говь брэндийг улам хүчирхэгжүүлнэ.



БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ГРС/гэмдэгтэй нь ашгийн төв
ГНРС/гэмдэгтэй нь ашгийн бүс төв

БРЭНДҮҮД

Монгол улсын хосгүй үнэт баялаг болсон Монгол ноолуурыг Дэлхийн зах зээлд брэнд болгохын тулд бүтээгдэхүүнээ илүү загварлаг, илүү тансаг, илүү эко болгохыг зорьж судалгаа хөгжүүлэлтийн ажлыг хийсээр ирсний жишээ нь бидний бий болгосон ORGANIC CASHMERE (будаг, химийн бодис хэрэглээгүй), YAMA (тансаг зэрэглэл) брэндүүд юм.

Дэлхийд танигдсан монгол брэнд GOBI
MONGOLIAN CASHMERE брэнд



MONGOLIAN CASHMERE

Ноолуурын байгалийн үндсэн 4 өнгө болох
цайвар, цайвар шаргал, хөх саарал, бор
өнгүүдийг ашигласан, будаагүй,
цайруулаагүй GOBI ORGANIC CASHMERE
брэнд

GOBI ORGANIC
MONGOLIAN CASHMERE

Илүү загварлаг, илүү тансаг зэрэглэлийн
YAMA брэнд

Монголоор "Ямаа" буюу тансаг, дулаан
ноолуурыг бий болгодог таван хошуу малын
нэгээр нэрлэсэн бол японоор Yama гэх үг нь
"Уулын оргил" гэсэн утгатай. Дэлхийн зах
зээлд хэдийнээ танигдсан GOBY брэнд тансаг
зэрэглэлийн ноолууран бүтээгдэхүүний зах
зээлд хүч үзэхийг билэгдэн ийнхүү нэрлэсэн.



Хүүхдийн хөдөлгөөнд саадгүй, хөнгөн,
зөөлөн, загварлаг GOBI KIDS хүүхдийн брэнд

GOBI KIDS




БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



ЭРЭЭН ХОТОД САЛБАР ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

2017 оны 1 сарын 13-нд БНХАУ-ын ӨМӨЗО-ны хурдацтай хөгжиж буй хотуудын нэг болох Эрээн хотын Минмао их дэлгүүрт салбар дэлгүүрээ нээв. Нээлтийн үеэр Эрээн хотын захиргаа, боомтын захиргаа, гаалийн газар зэрэг төрийн байгууллагуудын төлөөлөгчид болон Эрээн хотын бизнесийн төлөөлөгчид хүрэлцэн ирж оролцлоо.



ОНЛАЙН ХУДАЛДААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

2017 оны 2 сараас эхлэн гадаад зах зээл рүү чиглэн интернет худалдааг эхлүүлж ТАОВАО сайт дээр бүтээгдэхүүнээ байршуулж эхэлсэн.

Мөн www.gobicashmere.com гэсэн өөрийн онлайн худалдааны сайттай болсон.



БРЮССЕЛЬ ХОТОД САЛБАР ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

2017 оны 2 сарын 16-нд Бельги улсын нийслэл Брюссель хотод Говь брэндийн албан ёсны салбар дэлгүүрээ нээв. Нээлтэд Говь ХК-д түүхий эд нийлүүлэгч, хамтран ажиллагч малчдын төлөөл болсон Төв аймгийн Эрдэнэ сумын малчин Д.Эрдэнэ-Очирыг урьж оролцуулсан нь онцлог болов.



ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ДЭЭД ШАГНАЛ-ТӨРИЙН ГЭРЭГЭ ШАГНАЛ ХҮРТЛЭЭ

2017 оны 2 сарын 23-нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас "Үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал-Төрийн гэрэгэ" шагналыг Говь ХК-ийн Нэхмэлийн үйлдвэрийн ноолууран бүтээгдэхүүнд олголоо.



100,000 ШИРХЭГ НООЛУУРАН ПАЛЪТО ҮЙЛДВЭРЛЭХ ХҮЧИН ЧАДАЛТАЙ БОЛЛОО

2017 оны 4 сарын 3-нд Оёмолын шинэ үйлдвэрийн нээлтээ хийж оёмолын 2 үйлдвэртэй болсноор 100,000 ширхэг ноолууран пальто үйлдвэрлэх хүчин чадалтай боллоо.



"ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙРЫГ ЭРХЭМЛЭГЧ БАЙГУУЛЛАГА 2016" БОЛЗОЛТ УРАЛДААНЫ ТЭРГҮҮН БАЙРЫГ ЭЗЭЛЛЭЭ

2017 оны 4 сарын 12-нд ХНХЯам болон түүний харьяа ХАБЭМТөвөөс зохион байгуулсан "Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага 2016" уралдааны шагналын эздийг тодруулж, Говь ХК тэргүүн байрыг эзэллээ.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА


2017 оны 4 сарын 13-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх "Мираж" гэр ресторанд зохион байгууллаа. Хуралд нийт 6,688,649 саналын эрхтэй 88 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирж, хурлын ирц 85.74% байв.



ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖИД ШАЛГАРЛАА

2017 оны 4 сарын 27-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ТОП-100" ААН-ийг шалгаруулах ёслол болж, Говь ХК 18 дугаар байранд шалгарлаа.





АЖИЛЛАГСДЫН ТООГООР 5 ДУГААРТ ЖАГСЛАА

Говь ХК нь 1,600 гаруй ажилтантай бөгөөд Монгол улсын 2016 оны "ТОП-100" ААН-д ажиллагсдын тоогоороо 5 дугаарт жагслаа.



ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ АЖ АХУЙН НЭГЖЭЭР ШАЛГАРЛАА

Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүргээ нэр төртэй биелүүлэн улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсныг үнэлэн Монголын Татварын Ерөнхий Газраас 2016 оны "ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ" аж ахуй нэгжээр Говь ХК-ийг шалгарууллаа.



ХУВЬ ЗАХИАЛГААР НООЛУУРАН ПАЛЬТО БОЛОН ПИДЖАК ХИЙЖ ЭХЭЛЛЭЭ

2017 оны 5 сараас эхлэн Төв дэлгүүрийн дэргэдэх Хувь захиалгын төвд үйлчлүүлэгчдийн хүссэн хэмжээ, загвараар цор ганц давтагдашгүй ноолууран пальто болон пиджакийг урлаж эхэллээ.



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД ГОВЬ ХК ДЭЭР ЗОЧИЛОО

2017 оны 6 сарын 12-нд Хөдөө аж ахуйн салбар, аж үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хийгдсэн санхүүжилтийн үр дүн, төслийн хэрэгжилттэй танилцахаар Азийн Хөгжлийн Банкны нэр бүхий төлөөлөгчид Говь ХК дээр зочилж, компанийн үйл ажиллагаатай танилцлаа.

2017.06.14



ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТҮР ТАСАЛДЛАА

2017 оны 6 сарын 14-нд Говь ХК-ийн үйлдвэрийн барилгын дээвэрт гүйцэтгэгч компани нөхөн засварын ажил эхлүүлсэн бөгөөд энэ явцад барилгын дээвэрт гал гарч, гэнэтийн аюул тохиолдсон.

Компанийн Гүйцэтгэх удирдлагын баг галын аюулын үед шуурхай арга хэмжээ авч зарим түүхий эд, бүтээгдэхүүнийг аюулгүй газар байршуулсан бөгөөд гал унтраахтай холбогдон үйлдвэр дотор ус орж ирэхээс урьдчилан сэргийлж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг норхохоос сэргийлэн полиэтилен уутаар бүтээж амжсан.

2017.06.24



Онцгой байдлын ерөнхий газар, Ус сувгийн удирдах газар зэрэг Засгийн газрын харьяа байгууллагууд галын голомтод бүхий л нөөц бололцоо, хүчээ дайчлан шуурхай арга хэмжээ авч ажилласны үр дүнд дээвэрт гарсан галыг үйлдвэр дотогш орохоос өмнө унтрааж амжсан. Говь ХК-ийн хувьд тоног төхөөрөмж болон бараа материалын даатгалтай байсан.

ҮЙЛДВЭР ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭХЛҮҮЛЛЭЭ



Компанийн нийт ажилтнууд бүх хүчээ дайчлан үйлдвэр дотор хуралдсан усыг цэвэрлэж, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлаа ханган, засвараа бүрэн хийж дууссанаар 6 сарын 24-ний өдөр үйлдвэр хэвийн үйл ажиллагаагаа эхлүүлэв. Үйлдвэр хэвийн ажиллаж эхэлсэнтэй холбогдон 6 сарын 25-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, гэнэтийн эрсдэлийг богино хугацаанд давж, үйл ажиллагаагаа эхлүүлж чадсанд баяр хүргэж, амжилт хүслээ.



БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



100% ноолууран болон торгоны хольцтой пиджак



Эрэгтэй 2 талт пальто



3 өнгөний судалтай пальто



Хатгамалтай пальто



Бар принттэй, шинэ 90x90 см хэмжээтэй шааль



Жаккард хээтэй нэхмэл жин хөнгөрүүлсэн хөнжил




Япон технологийн хатгамал мэт харагдах 3D принттэй шааль



Хэвэлмэл торгон (Evok) утастай загвар

ШИНЭ КОЛЛЕКЦИУД



ЦАГААН САР 2017



ХАВАР/ЗУН 2017



YAMA ХАВАР/ЗУН 2017



НААДАМ 2017

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН



МАЛЧДАД БОГ МАЛЫН НЭМНЭЭ ХАНДИВЛАВ

Жил бүрийн хаврын улиралд түүхий эд татан авах ажлаар компанийн ажилчид хөдөө орон нутгийг зорин малчидтай уулздаг бөгөөд энэ жил түүхий эд татан авалтын ажлын хүрээнд нийт ажилтнуудын дунд "Хэн хамгийн их бог малын нэмнээ хандивлах вэ" уралдаан зарлаж нийт 120 ажилтнаас 614 ширхэг нэмнээ цугларан түүхий эд бэлтгэлийн үеэрээ малчдад хандивлав.



ЦУСНЫ ДОНОРЫН ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Хан-Уул дүүргийн Улаан загалмайн хорооноос Говь ХК-тай хамтран "Цусны донорын өдөрлөг"-ийг зохион байгуулж, нийт 109 ажилтан нийт 12 литрийн цус хандивласан ба 9 хүний эрдэнэт амийг аварсан билээ.



НООЛУУРАН ХӨНЖИЛ БЭЛЭГЛЭВ

Бүсгүй хүний нинжин сэтгэл, тэвчээр хатуужлаараа эцэг эхгүй, эцэг эх нь өсгөх боломжгүй 31 хүүхдийн эх болж тэднийг эхийн хайраар дутаалгүй өсгөж байгаа Сарнай бүсгүйд сэтгэлийн бэлэг болгон ноолууран хөнжил болон Үндэсний Соёл Амралын Хүрээлэнд тоглох тасалбарыг хүүхэд бүрд бэлэглэв.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДЭД ГАРЫН БЭЛЭГ ХҮРГҮҮЛЭВ

Хүүхэд бүхэн баярлаж, инээд хөөрөөр дүүрэн байх эрхтэй "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан баяр дээр нь баяр нэмэхийн төлөө Хан-Уул дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн төлөөлөлтэй уулзан, 100 хүүхэдэд гарын бэлэг хүргүүлэв.



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2017.06.30			2016.06.30 гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт		тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	<i>сая.төг</i>	37,670	33,946	90%	25,065	8,881	35%
Дотоод борлуулалт	<i>сая.төг</i>	25,010	23,778	95%	15,729	8,049	51%
Гадаад борлуулалт	<i>сая.төг</i>	12,660	10,168	80%	9,336	832	9%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	<i>сая.төг</i>	23,235	20,163	87%	15,456	4,707	30%
НИЙТ АШИГ	<i>сая.төг</i>	14,435	13,783	95%	9,608	4,174	43%
Үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	10,019	9,286	93%	5,988	3,297	55%
Татварын өмнөх ашиг	<i>сая.төг</i>	4,416	4,497	102%	3,620	877	24%
ЦЭВЭР АШИГ	<i>сая.төг</i>	3,762	3,395	90%	3,162	233	7%
Цэвэр ашгийн хувь	<i>хувь</i>	10%	10%	100%	13%	0	-21%
Экспорт	<i>мян.USD</i>	4,700	4,200	89%	4,801	-601	-13%
Нийт үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	33,254	29,449	89%	21,445	8,004	37%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	<i>төгрөг</i>	0.88	0.87	98%	0.86		
ҮЙЛДВЭРЛЭЛТ							
Сүлжмэл	<i>ширхэг</i>	246,005	256,859	104%	227,850	29,009	13%
Нэхмэл	<i>метр</i>	161,642	152,907	95%	120,680	32,227	27%
Оёмол	<i>ширхэг</i>	25,520	26,561	104%	13,887	12,674	91%
Үүнээс: Пальто	<i>ширхэг</i>	24,030	23,432	98%	6,899	16,533	240%
Ээрмэл	<i>тонн</i>	184	152	82%	126	26	20%
ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ							
Ноолуур	<i>тонн</i>	650	584	90%	349	235	67%
АЖИЛЛАГСДЫН ТОО	<i>хүн</i>	1,751	1,606	92%	1,399	207	15%
Нэг ажилтанд ногдох орлого	<i>мян.төг</i>	21,513	21,137	98%	17,916	3,221	18%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	<i>сая.төг</i>	4,744	6,842	144%	1,314	5,528	421%


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Цэвэр ашиг
3.4
тэрбум төг



Төлсөн татвар
6.0
тэрбум төг



Хөрөнгө оруулалт
6.8
тэрбум төг

ДОТООД ЗАХ ЗЭЭЛ



Дотоод борлуулалт
23.8
тэрбум төг



Дотоодын зах зээлд эзлэх %
68%



Нэрийн барааны дэлгүүр
8

ГАДААД ЗАХ ЗЭЭЛ



Экспорт
4.2
мян. доллар



34 орны
160+
харилцагч



Нэрийн дэлгүүр

Франчайз дэлгүүр

11 орны
26 хотод
3
57

ҮЙЛДВЭРЛЭЛТ



Сүлжмэл
257
мян. шир



Нэхмэл
153
мян. метр



Оёмол
27
мян. шир

ХҮНИЙ НӨӨЦ



Ажиллагсдын тоо
1,606



Эрэгтэй
25%
Эмэгтэй
75%



Захиргаа
207
Үйлдвэр
1,224
Борлуулалт
175



НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 6 сарын 30
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2017.06.30	2016.12.31
ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,901,927	2,614,270
Дансны ба бусад авлага	7,977,989	19,519,521
Урьдчилгаа төлбөр	4,106,183	2,719,652
Бараа материал	113,328,595	58,737,861
	135,314,694	83,591,304
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	57,489,877	52,035,760
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	9,000	245,742
	57,498,877	52,281,502
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	192,813,571	135,872,806
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Дансны ба бусад өглөг	26,597,357	4,298,237
Орлогын албан татварын өглөг	562,629	2,196,930
Богино хугацаат банкны зээл	33,011,920	31,678,103
	60,171,906	38,173,270
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Хойшлогдсон татварын өр төлбөр	227,757	63,993
Урт хугацаат банкны зээл	44,790,433	11,836,840
	45,018,190	11,900,833
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	105,190,096	50,074,103
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	15,647,697	15,647,697
Хуримтлагдсан ашиг	71,195,666	69,370,893
	87,623,475	85,798,703
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	192,813,571	135,872,806

НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

2017 оны 6 сарын 30
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2017.06.30	2016.12.31
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	33,945,580	88,673,668
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(20,162,936)	(52,454,588)
НИЙТ АШИГ	13,782,644	36,219,080
Санхүүгийн ба бусад орлого	876,429	1,914,467
Бусад олз ба (гарз)	(53,676)	2,034,960
Хүүгийн зардал	(2,544,923)	(4,171,500)
Борлуулалт ба маркетингийн зардал	(3,892,460)	(8,169,197)
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,671,226)	(6,692,310)
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	4,496,788	21,135,500
Орлогын татварын зардал	(1,101,322)	(4,996,596)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ	3,395,466	16,138,904
Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдахгүй бусад иж бүрэн орлого:		
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний олз	-	2,276,718
НИЙТ ИЖ БҮРЭН ОРЛОГО	3,395,466	18,415,622
НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ	0.44	2.07

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 6 сарын 30
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	ХУВЬЦААТ КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ХУРИМТЛАГДСАН АШИГ	НИЙТ
2015.12.31 ҮЛДЭГДЭЛ	780,113	13,370,979	54,324,146	68,475,238
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	16,138,904	16,138,904
Бусад иж бүрэн орлого	-	2,276,718	-	2,276,718
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	2,276,718	16,138,904	18,415,622
Зарласан ногдол ашиг	-	-	(1,092,157)	(1,092,157)
2016.12.31 ҮЛДЭГДЭЛ	780,113	15,647,697	69,370,893	85,798,703
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	3,395,466	3,395,466
Бусад иж бүрэн орлого	-	-	(10,468)	(10,468)
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	3,384,998	3,384,998
Зарласан ногдол ашиг	-	-	(1,560,225)	(1,560,225)
2017.06.30 ҮЛДЭГДЭЛ	780,113	15,647,697	71,195,666	87,623,476

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 6 сарын 30
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2017.06.30	2016.12.31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ТАЙЛАНТ ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ	3,395,466	16,138,904
Тохируулгууд:		
Элэгдэл ба хорогдлын зардал	2,677,575	4,535,367
Орлогын татварын зардал	1,101,322	4,996,596
Хүүгийн зардал	2,544,923	4,171,500
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (ашиг)/алдагдал	(634,658)	(438,320)
Найдваргүй авлагын зардал	-	13,139
Бараа материалын хасагдуулгын зардал/(нөхөлт)	-	178,829
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз/(олз)	26,693	140,720
	9,111,320	29,736,735
Дансны ба бусад авлагын өсөлт	(11,541,532)	(1,224,032)
Урьдчилгаа төлбөрийн бууралт/(өсөлт)	(1,386,531)	5,872,378
Бараа материалын өсөлт	(54,590,734)	(12,549,907)
Дансны ба бусад өглөгийн өсөлт/(бууралт)	16,900,115	493,877
	(41,507,361)	22,329,051
Төлсөн орлогын татвар	(2,725,691)	(3,034,060)
Төлсөн хүү	(2,842,073)	(4,228,509)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(47,075,125)	15,066,482
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН Ү/А-НЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө	10,466	49,505
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(6,354,410)	(16,178,831)
Худалдан авсан бусад эргэлтийн бус хөрөнгө	-	(252,993)
Холбоотой талд өгсөн санхүүжилт	(11,292,637)	(22,300,000)
Холбоотой талд өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	36,924,000	15,697,789
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН Ү/А-НЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	19,287,419	(22,984,530)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Авсан зээл	48,434,997	12,308,009
Төлсөн зээл	(12,811,432)	(18,808,060)
Төлсөн ногдол ашиг	(523,677)	(972,695)
САНХҮҮГИЙН Ү/А-НЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	35,099,888	(7,472,746)
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	(24,526)	(6,285)
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН (БУУРАЛТ)/ӨСӨЛТ	7,287,657	(15,397,079)
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	2,614,270	18,011,349
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	9,901,927	2,614,270

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Доорх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд нь зах зээлийн нөхцлөөр хийгдсэн болно.
(мян. төг)

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ	2017.06.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	10,768,960
Холбоотой талаас авсан санхүүжилт	22,924,000
Холбоотой талтай хийсэн борлуулалт	-
Холбоотой талаас авсан худалдан авалт	245,332
Хүүгийн орлого	305,683
Хүүгийн зардал	364,421
Түрээс орлого	47,273
Түрээс зардал	27,919

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

(мян. төг)

БАНКНЫ НЭР	2017.06.30	2016.12.31	ЭЗЛЭХ ХУВЬ
Голомт банк	24,251,844	18,685,242	31%
Худалдаа Хөгжлийн Банк	23,915,260	22,480,000	31%
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк	9,396,840		12%
Хаан Банк	143,149	145,928	0.2%
Хас Банк	14,095,260	-	18%
Азийн Хөгжлийн Банк	6,000,000	2,076,840	8%
ЗЭЭЛИЙН ДҮН	77,802,353	43,388,010	100%

КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ


(мян. төг)

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2017.06.30	2016.06.30
ТУЗ-ийн цалин урамшуулал	45,100	55,350
Удирдлагын цалин урамшуулал	212,122	211,317
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	16,766	10,161
НИЙТ	273,988	276,828



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

ҮЗҮҮЛЭЛТ	2017.06.30		2016.12.31	2016.06.30	
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО (шир)	7,801,125		7,801,125	7,801,125	
Төрөл	энгийн хувьцаа		энгийн хувьцаа	энгийн хувьцаа	
ХУВЬЦААНЫ ҮНЭ (төг)	Өсөлт, бууралт /%/				
		2016.12.31- нээс	2016.06.30- наас		
Хаалтын үнэ	13,050	28.6% ↑	56.5% ↑	10,150	8,340
Хамгийн их үнэ	14,810	27.1% ↑	74.2% ↑	11,650	8,500
Хамгийн бага үнэ	9,600	35.2% ↑	35.2% ↑	7,100	7,100
Дундаж үнэ	12,462	45.9% ↑	54.9% ↑	8,540	8,046
АРИЛЖААЛАГДСАН ТОО (шир)	50,161	15.4% ↓	82.5% ↑	59,302	27,492
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН (мян. төг)	629,740	22.5% ↑	183.2% ↑	514,091	222,345
КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (мян. төг)	101,804,681	28.6% ↑	56.5% ↑	79,181,419	65,061,383

НОГДОЛ АШИГ

НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (мян. төг)	Ногдол ашиг тараалт
1996	61	475,869	Говь ХК 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
1997	154	1,199,813	
1998	150	1,170,169	
1999	166	1,294,987	
2000	100	780,113	
2001	20	157,271	
2005	60	468,068	
2006	60	468,068	
2010	100	780,113	ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% тараасан.
2011	100	780,113	
2012	125	975,141	
2013	130	1,014,146	
2014	140	1,092,158	
2015	140	1,092,158	2016.06.01-нээс эхлэн компани дээрээ тарааж байгаад 2017.06.30-нд ҮЦТХТ-өөр зуучлуулан үлдэгдлийг нь 100% тараасан.
2016	200	1,560,225	Компани дээрээ тарааж байна.

2016 ОНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ, ТҮҮНИЙГ ТАРААХ ЖУРАМ

Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 2 сарын 10-ны өдрийн хурлын №2 тогтоолоор 2016 оны санхүүгийн үр дүнгээс хувьцааны нэгж тутамд 200 төгрөгийн ногдол ашиг буюу цэвэр ашгийн 9.7 хувийг ногдол ашигт тараахаар боллоо. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нэгж хувьцаанд ногдол ашгийн хэмжээ 42.8 хувиар өссөн үзүүлэлттэй байв.

2016 оны ногдол ашгийг 2016 оны 4 сарын 20-ны өдрөөс эхлэн компани дээрээ бэлэн мөнгөөр тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгож байна.


2017 оны 6 сарын 30-ны байдлаар 135 хувьцаа эзэмшигчийн 2,261,800 төгрөгийн ногдол ашгийг тараагаад байна. Ногдол ашгийн үлдэгдлийг энэ ондоо багтаан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх болно.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Говь хувьцаат компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



Манай компани шинэчлэн батлагдсан Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, гаднын компаниудын сайн засаглалын туршлагаас суралцан Сайн засаглалыг нэвтрүүлэх, компанийн засаглалаар манлайлахаар чармайн ажиллаж ирсэн бөгөөд Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг идэвхжүүлэхээр Компанийн засаглалын үндэсний зөвлөл /КЗҮЗ/, Монголын хөрөнгийн бирж /МХБ/-ээс санаачилсан “Сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах “ТУНХАГ БИЧИГ”-т нэгдэн ажиллаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ 5%-ААС ДЭЭШ БАГЦЫГ ЭЗЭМШИГЧДЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ:

Тайлангийн хугацаанд Таван Богд Трейд ХХК (хувьцааны тоо: 1,239,796 ширхэг, эзэмшлийн хувь: 15.9%) нь Үлэмж Их ХХК (хувьцааны тоо: 438,829 ширхэг, эзэмшлийн хувь: 5.6%)-ийг нэгтгэсэнтэй холбогдон, Говь ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Таван Богд Трейд ХХК нь Говь ХК-ийн 1,678,625 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 21.5%-ыг эзэмшдэг болсон.

ХУВЬЦААНЫ 5%-С ДЭЭШ БАГЦЫГ ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо (мян. шир)	Эзэмшлийн хувь
ХИДЕ ИНТЕР ХХК	2,652.4	34.0%
ЭФ-СИ-АЙ ХХК	2,230.0	28.6%
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	1,678.6	21.5%

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

7,801,125

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

16,102

/2017.06.30-ны байдлаар/

ХИДЕ ИНТЕР ХХК, ЭФ-СИ-АЙ ХХК нь хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

ТАВАН БОГД ТРЕЙД ХХК нь “Таван Богд Групп”-ийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хурлыг 2017 оны 4 сарын 13-ны өдөр 6,688,649 саналын эрхтэй 90 хувьцаа эзэмшигч оролцож, 85.74 хувийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2016 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2016 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.97%-ийн саналаар батлав.
2. 2015 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2016 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийг батлахад кумулятив аргаар санал хураалт явуулан, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр М.Баяр, Д.Гэрэлмаа, Б.Нандин-Эрдэнэ, Т.Одмаа, Такэши Камбэ нарыг, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ц.Баатарсайхан, Хидэо Савада, Д.Хулан, Ж.Оюунчимэг нарыг тус тус 3 жилийн хугацаатайгаар сонгох шийдвэр гаргалаа.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Эрсдэл, аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Цалин, урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

2017 онд Төлөөлөн удирдах зөвлөл 3 удаа, Эрсдэл, аудитын хороо 2 удаа, тус тус хуралдаж, холбогдох чиг үүргийн хүрээнд нийт 25 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн, 22 тогтоол гарган, компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**Дамба
ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга
Хараат бус гишүүн

Эдийн засагч
СЭЗДС, Бизнес
удирдлагын тэнхимийн
профессор



**Цагаач
БААТАРСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

*Электроникийн
инженер*
Таван Богд Группийн
Ерөнхийлөгч,
Говь ХК-ийн Гүйцэтгэх
захирал



**Дашдаваа
ХУЛАН**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

Эдийн засагч
Таван Богд Группийн
Тэргүүн дэд
ерөнхийлөгч



**Хидэо
САВАДА**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

Эдийн засагч
Н.И.С компанийн
Ерөнхийлөгч



**Такэши
КАМБЭ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Эдийн засагч
Asahi Life Insurance
Менежер



**Түнрэв
ОДМАА**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Эдийн засагч
Ланддорф финанс
ББСБ-ийн Гүйцэтгэх
захирал



**Мягмар
БАЯР**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

*Оёдлын үйлдвэрийн
технологич инженер*
ШУТИС-ийн ҮТС-ийн
Нэхмэл судлалын
салбарын дэд профессор



**Жавзандолгор
ОЮУНЧИМЭГ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Сэтгүүлч
Таван Богд Групп,
Маркетингийн
хэлтсийн дарга





**Банзрагч
НАНДИН-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

*Бизнесийн
Удирдлага*
СЭЗДС, Бизнесийн
Удирдлагын тэнхимийн
ахлах багш



КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

ОВОГ НЭР АЛБАН ТУШААЛ	МЭРГЭЖИЛ АЖЛЫН ТУРШЛАГА
 <p data-bbox="542 493 784 564">Цагаач БААТАРСАЙХАН</p> <p data-bbox="594 606 732 672">Гүйцэтгэх захирал</p>	<p data-bbox="810 373 1240 407">ЭЛЕКТРОНИКИЙН ИНЖЕНЕР</p> <p data-bbox="810 434 1466 611">Алтай компанид Орлогч захирал, Таван Богд Трейд ХХК, Жуулчин ХХК, МИАТ компаниудын Ерөнхий захирал, Палас зочид буудлын Гүйцэтгэх захирлын албан тушаалуудыг хашиж байсан.</p> <p data-bbox="810 657 1466 795">Таван Богд группийн Ерөнхийлөгч, Хаан банкны ТУЗ-ийн гишүүн, 2008 оны 8 сараас Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.</p>
 <p data-bbox="555 949 771 1020">Нямжав СҮРЭНРАГЧАА</p> <p data-bbox="558 1062 768 1165">Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал</p>	<p data-bbox="810 869 1045 903">ЭДИЙН ЗАСАГЧ</p> <p data-bbox="810 953 1466 1022">Таван богд трейд ХХК-д Төслийн мэргэжилтэн, Төслийн туслах менежерээр ажиллаж байсан.</p> <p data-bbox="810 1064 1466 1203">2015 оны 4 сараас Говь ХК-ийн Бизнес удирдлагын газрын захирлаар, мөн оны 11 сараас Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлаар томилогдон ажиллаж байна.</p>
 <p data-bbox="607 1446 719 1518">Лувсан АРИУН</p> <p data-bbox="545 1560 781 1663">Гадаад худалдаа хариуцсан дэд захирал</p>	<p data-bbox="810 1329 1216 1362">МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР</p> <p data-bbox="810 1411 1466 1549">KVN Co.Ltd-д Маркетингийн менежер, KVN Co.Ltd-ийн Хонг Конг дахь салбарын Маркетингийн ахлах менежерээр ажиллаж байсан.</p> <p data-bbox="810 1596 1466 1810">2015 оны 7 сараас Говь ХК-ийн Менежмент удирдлагын хэлтэст Бодлого журам хариуцсан менежер, 2015 оны 11 сараас Борлуулалт хариуцсан дэд захирал, 2017 оны 1 сараас Гадаад борлуулалт хариуцсан дэд захирлаар томилогдон ажиллаж байна.</p>



Болд ТҮВШИНТӨГС

Дотоод
худалдааны
газрын захирал

САНХҮҮГИЙН МЕНЕЖЕР

Монгол Дайвин ХХК-д Инновацийн албаны дарга, Таван Богд Трейд ХХК-д Менежмент удирдлага хариуцсан менежер, Дельта Холдинг ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

2017 оны 5 сараас Говь ХК-д Дотоод худалдааны газрын захирлаар ажиллаж байна.



Ганболд СЭЛЭНГЭ

Санхүү бүртгэл,
удирдлагын
газрын захирал

САНХҮҮ, БИЗНЕСИЙН УДИРДЛАГА

“Гермес Тэсүн” ХХК-д Ерөнхий нягтлан бодогч, “Хаан Палас” ХХК-д ахлах нягтлан бодогч, Таван Богд Групп-д нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан.

2013 оноос одоог хүртэл Говь ХК-д Санхүү бүртгэл, удирдлагын газрын захирлаар ажиллаж байна.



Батсуурь БОЛОРМАА

Бүтээгдэхүүн
хөгжүүлэлтийн
газрын захирал

ЗАГВАР ЗОХИОН БҮТЭЭГЧ

Дархан минж” ХХК-д Дизайнерээр ажиллаж байсан.

2007 оноос “Говь” ХК-д чанар шалгагч, 2008 оноос дизайнер, загвар зохион бүтээгч, 2016 оноос Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын захирлаар ажиллаж байна.



Чулуунбат СОЛОНГО

Захиргаа, хүний
нөөцийн газрын
захирал

АРХИТЕКТОР

“Алтандорнод Монгол” ХХК-д Гадаад харилцааны менежер, Боловсон хүчин, Таван Богд Групп-д Гадаад худалдааны менежер, Борлуулалт хариуцсан ахлах менежерээр тус тус ажиллаж байсан.

2014 оноос “Говь” ХК-д Захиргаа, хүний нөөцийн газрын захирлаар ажиллаж байна.





**Цогтбаяр
ЦАСЧИХЭР**

Хуулийн зөвлөх

ЭРХ ЗҮЙЧ

Хэнтий аймгийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Жаст Ойл ХХК-д Хуулийн зөвлөх, Эм Си Эс ХХК-д Хуульчаар тус тус ажиллаж байсан.

2014 оноос “Говь” ХК-д Хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.



**Мөнхбат
СЭЛЭНГЭ**

ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга

НЯГТЛАН БОДОГЧ

Нью Хакуба ХХК-д Нягтлан бодогч, Бүрд Петролиум ХХК-д Нягтлан бодогч, Таван Богд Трейд ХХК-д Төслийн туслах менежер, Менежмент удирдлага хариуцсан менежер, Захирлын ажлын албаны менежерээр ажиллаж байсан.

2017 оноос “Говь” ХК-д ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ	
	ДАНГААРАА	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД
Д.ХУЛАН	122,473ш (1.6%)	ЭФ-СИ-АЙ ХХК 28.6% ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 21.5%
Ц.БААТАРСАЙХАН	500ш (0.0%)	
НИЙТ	51.7%	

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081
Имэйл: info@gobi.mn